



СЭЛБЭ ДЭД ТӨВИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НӨЛӨӨЛӨЛД ӨРТСӨН  
ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХАШАА, БАЙГУУЛАМЖ, ЭД ХӨРӨНГИЙН  
ЦЭВЭРЛЭГЭЭ АРИУУТГАЛ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ  
**АЖЛЫН ДААЛГАВАР**

(ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ 14, 18 ДУГААР ХОРОО, СҮХБААТАР ДҮҮРЭГ 14 ДҮГЭЭР ХОРОО)

2024 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

1	Төсөл боловсруулах үндэслэл	- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 25 дугаар тогтоол, - Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/578 дугаар захирамж
2	Байршил, хэмжээ, хүчин чадал	Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны 158 га газрын төсөл хэрэгжих нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн газар, эд хөрөнгө
3	Ажил гүйцэтгэх хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
4	Зориулалт	Сэлбэ дэд төвийн төсөл, арга хэмжээний нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн газар, нэгж талбарыг чөлөөлөх, хог хаягдлыг цэвэрлэх, тээвэрлэх, нөхөн сэргээх, барилгажилт явагдах талбайг бэлтгэх, ариутгаж халдвартгүйжүүлэх.
5	Ажил гүйцэтгэхэд ашиглах хууль, тогтоомж, норм, стандарт	<b>Хууль тогтоомжууд:</b> -Хог хаягдлын тухай хууль -Эрүүл ахуйн тухай хууль <b>Тушаал:</b> Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2024 оны 02 дугаар сарын А/96, А/104, А/81 дүгээр тушаал <b>Норм, дурэм:</b> -Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД12-101-05 -Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 48-р тушаалаар батлагдсан “Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам, -БОАЖС-ын 2018 оны А/444 дүгээр тушаалаар батлагдсан Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага” <b>Стандартууд:</b> MNS 5346:2017 Автомэханик хэрэгслийн ачаа тээвэрлэх ба тээвэрлэлтэд зуучлах үйлчилгээ MNS 5924: 2015 Нүхэн жорлон, угаадасны нух. Техникийн шаардлага

		MNS BS 5906:2018 Барилга доторхи хог хаягдлын менежмент <b>Ашиглалтын дүрэм</b> Хотын стандарт UCS:0001-01:2019 “Барилга ба замын ажлын ажлын үед иргэдийн аюулгүй байдлыг хангах”
6	Гүйцэтгэх ажил	<p>-Чөлөөлөлт, буулгалтаас үлдсэн хог хаягдлыг ангилах, ачиж тээвэрлэх, зөвшөөрөгдсөн төвлөрсөн хогийн цэгт хүргэх,</p> <p>-Чөлөөлөлтийн явцад инженерийн шугам сүлжээний үзлэгийн худаг, борооны ус зайлцуулах, хөрсний усны худаг, байгууламжуудыг ашиглагч байгууллагуудад мэдэгдэж хүлээлгэн өгөх,</p> <p>-Цахилгаан, гэрэлтүүлгийн кабель монтажинд тодруулга хийж, ашиглалт, арчлалтын аюулгүй байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд шилжүүлэх</p> <p>-Хайс хашлага, сандал хогийн сав, ногоон байгууламж болон бусад нийтийн эзэмшилийн эд хөрөнгүүдийг ашиглалт, арчлалт хариуцсан байгууллага (Дүүрэг, газрын алба, ашиглагч байгууллага)-д хүлээлгэн өгөх, нүүлгэн шилжүүлэх,</p> <p>-Чөлөөлөлт хийгдсэн байршуудад хөрсийг тэгшлэх, нөхөн сэргээх, үер ус тогтохоос сэргийлэх,</p> <p>-Бохир усны цооног, нүхэн жорлон, бие засах газрын бохирыг соруулах, булшлах, нүүлгэн шилжүүлэх,</p> <p>-Бие засах газар, бохирын цооногийн бохирыг соруулах, ариутгал халдвартгуйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, халдварт өвчин тархахаас сэргийлэх,</p> <p>-Халдвартгуйжсэн нийтийн бие засах газар, бохирын цооног, нүхийг эрүүл хөрсөөр дүүргэж, булах, тэгшлэх,</p> <p>-Ойр орчин болон суурин газрын аюулгүй байдал, байгаль орчны чанарыг хангаж ажиллах.</p> <p>-Айл өрхүүдийн ариун цэврийн байгууламж, бохирын цооногийн ариутгалд байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, биологийн гаралтай, Мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй биобэлдмэл ашиглах.</p> <p>-Нүхэн жорлонгийн лаг задлах, эвгүй үнэрийг дарах, ариутган халдвартгуйжүүлэх үйлчилгээтэй байх.</p> <p>-Олон улсад хэрэглэгддэг, Монгол орны нөхцөлд тохирсон, үр дүн үзүүлсэн нь шинжлэх ухааны туршилт судалгаагаар батлагдсан, сүүлийн 5-аас доошгүй жил ариутгал, халдвартгуйтгэлийн чиглэлээр ашигласан бэлдмэл байх.</p> <p>Чөлөөлөлт, буулгалт, цэвэрлэгээ, халдвартгуйжүүлэх ажлын явцад Захиалагч болон төсөл хэрэгжүүлэгч, Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн ажилтан албан хаагч нартай мэдээллийг шуурхай солилцож, ажлын явцыг мэдээллэж, нягт хамтран ажиллана.</p>
7	Захиалагч байгууллага	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
8	Төслийн иж бүрдэл	Бусад холбогдох материал
9	Төсөл хэрэгжүүлэх ажил, үйлчилгээний нөхцөл	-Гүйцэтгэгч нь нөлөөлөлд ёртсөн иргэн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгууламжийг буулгах, тээвэрлэх, хогийн цэгт хүргэх, орчны эрүүл ахуй халдварт хамгааллыг сахиж, ариутгаж халдвартгуйжүүлэхдээ машин механизм, багаж хэрэгсэл, материал, бодис хэрэгслэлийн

		бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, сүл зогсолт гаргалгүй, зохион байгуулалт сайтай ажиллах. -Гүйцэтгэгч нь чөлөөлөлт, буулгалт, тээвэрлэлтийн явцад өөрийн ажилчдын болон хяналт тавих, хамтран ажиллах байгууллага нэгжийн ажлын цагийг уялдуулан тооцож ажиллахыг шаардах. Гүйцэтгэгч нь ажлын гүйцэтгэлийн тайлан, гэрээ дүгнэсэн акт, үйлдэж захиалагчид хүлээлгэн өгнө.
10	Ерөнхий шаардлага	Цаг агаарын нөхцөл байдал болон нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн газар чөлөөлөлтийн нөхцөл байдалтай уялдуулан ажлын төлөвлөгөө, график гарган хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага ханган ажиллана.

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, ЦЭВЭРЛЭГЭЭ  
АРИУТГАЛЫН АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

Д\д	Ажлын нэр	Нийт талбай /га/	Нэгж талбараар
1.	Хог хаягдлыг нүүлгэн шилжүүлэх, ачиж тээвэрлэх	СБД Блок 1 - 27.49 га СБД Блок 2 - 27.11 га СБД Блок 3 - 23.92 га	СБД Блок 1 - 354 н/т СБД Блок 2 – 296 н/т СБД Блок 3 – 372 н/т
2.	Бохир соруулах (нүхэн жорлон, угаадасны нүх, булсан жорлон г.м)	СБД Блок 1 - 27.49 га СБД Блок 2 - 27.11 га СБД Блок 3 - 23.92 га	СБД Блок 1 - 354 н/т СБД Блок 2 – 296 н/т СБД Блок 3 – 372 н/т
3.	Ариутгал халдвартгүйжүүлэлт хийх (нүхэн жорлон, угаадасны нүх, булсан жорлон г.м)	СБД Блок 1 - 27.49 га СБД Блок 2 - 27.11 га СБД Блок 3 - 23.92 га	СБД Блок 1 - 354 н/т СБД Блок 2 – 296 н/т СБД Блок 3 – 372 н/т
	Нийт	78.52 га	1022 н/т

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, ЦЭВЭРЛЭГЭЭ  
АРИУТГАЛЫН АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

Д\д	Ажлын нэр	Нийт талбай /га/	Нэгж талбараар
1.	Хог хаягдлыг нүүлгэн шилжүүлэх, ачиж тээвэрлэх	ЧД Блок 1 - 27.67 /га/ ЧД Блок 2 - 23.63 /га/ ЧД Блок 3 - 29.45 /га/	ЧД Блок 1 - 436 н/т ЧД Блок 2 – 356 н/т ЧД Блок 3 – 392 н/т
2.	Бохир соруулах (нүхэн жорлон, угаадасны нүх, булсан жорлон г.м)	ЧД Блок 1 - 27.67 /га/ ЧД Блок 2 - 23.63 /га/ ЧД Блок 3 - 29.45 /га/	ЧД Блок 1 - 436 н/т ЧД Блок 2 – 356 н/т ЧД Блок 3 – 392 н/т
3.	Ариутгал халдвартгүйжүүлэлт хийх (нүхэн жорлон, угаадасны нүх, булсан жорлон г.м)	ЧД Блок 1 - 27.67 /га/ ЧД Блок 2 - 23.63 /га/ ЧД Блок 3 - 29.45 /га/	ЧД Блок 1 - 436 н/т ЧД Блок 2 – 356 н/т ЧД Блок 3 – 392 н/т
	Нийт	80.75 га	1184 н/т

Тайлбар: н/т- нэгж талбар

БОЛОВСРУУЛСАН: БАРИЛГА БАЙГУУЛАМЖ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

*О. Эрдэнэ-Отгон*

О.ЭРДЭНЭ-ОТГОН



НИЙСЛЭЛИЙН ОРОН  
СУУЦНЫ КОРПОРАЦИ

